



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.08.15 № 01/1600

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдөр зарласан ЭТТХК/20240102486/01/01 дугаартай “Ханын видео лед дэлгэц” нийлүүлэх тендерийг сонирхогч этгээдүүдээс тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хариу хүргүүлж байна. Үүнд:

Д/д	Тодруулгын асуулт	Хариулт
1.	Техникийн тодорхойлолтод 30 ширхэг видео дэлгэцийг хоёр байршилд суурилуулахаар заасан байгаа бөгөөд тухайн хоёр байршил тус бүрд хэдэн дэлгэцийг ямар харьцаатайгаар суурилуулах нь тодорхойгүй байна. Иймд заагдсан хоёр байршилд тус бүр хэдэн дэлгэцийг хэдийг харьцах хэдтэйгээр суурилуулах тухай тодруулж өгнө үү.	1. Өмнөговь аймаг, Цогтцэций суманд байрлах салбарын Green Center оффисын шуурхай удирдлагын өрөөнд 15 ширхэг дэлгэцийг 5x3 (урт, өндөр) дэлгэцийн харьцаагаар суурилуулна. 2. Чингэлтэй дүүрэг, 1-р хороонд байрлах төв оффисын 1 давхрын удирдлагын өрөөнд 9 ширхэг дэлгэцийг 3x3 /урт, өндөр/ харьцаагаар суурилуулна. 3. Үлдсэн 6 дэлгэцийг тогтоогчийн хамт агуулахад хүлээн авна. Суурилуулалт шаардлагагүй болно.
2.	Нийт дэлгэцийн нягтаршил, харах өнцгийн мэдээлэл илгээж өгнө үү?	Дэлгэцийн нягтаршил: 1920x1080 @60 Hz Харах өнцөг: Босоо 178 градус, Хэвтээ 178 градус
3.	Тус дэлгэцийг видео валл-р сольж болох уу?	Энэ видео валл дэлгэцийн техникийн тодорхойлолт болно.
4.	Дэлгэцүүд ижил контентг харуулах шаардлагатай юу эсвэл дэлгэц бүр өөр өөр дүрс харуулах шаардлагатай юу?	Дэлгэцүүд ижил контент харуулахгүй, өөр өөр дүрс харуулах зорилготой.
5.	Декодерийн (контроллерын) оролтын тоо болон форматын мэдээлэл оруулна уу?	Оролт: 1 VGA, 1 DVI Гаралт: 16 HDMI, 8 BNC
6.	Тендерийн нэр нь Лед гэж байгаа боловч техникийн тодорхойлолтод LCD гэж оруулсан байгаа учир Дэлгэц нь LED байх уу эсвэл LCD байх уу?	Дэлгэц нь LED эсвэл LCD аль нь ч байж болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124043895